



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудит

Ерөнхий дүгнэлт: Аймаг, сумдын засаг захиргаа болон мэргэжлийн байгууллагуудын хяналт, шалгалтын үйл ажиллагаа үр нөлөөтэй хийгдэхгүй байгаагаас хууль бус алт олборлолт, ойн санг сүйтгэх, газрын гүний усыг бохирдуулах, нөхөн сэргээлт хийхгүй орхих зэрэг сөрөг үйл ажиллагааг таслан зогсоож чадахгүй байна.



Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын харьяа
Сэлэнгэ аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Ахлах аудитор
С.Бат-Эрдэнэ
Аудитор Б.Эрдэнэзул

2015 оны 10 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
7036-2442 дугаарын
утас, 7036-3040
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:Сэлэнгэ аймгийн
Сүхбаатар сум, аймгийн
ЗДТГ-ын байрны
Өргөтгөлд

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Хоёр. Үндсэн мэдээлэл
Гурав. Аудитын дүн

1. Уул, уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу тооцож төвлөрүүлсэн эсэх.

1.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах зардлыг журамд заасан хувь хэмжээгээр үнэн зөв тооцож байна уу?

1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүдээс нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг бүрэн төвлөрүүлж байна уу?

2. Төвлөрүүлсэн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу зарцуулсан эсэх

2.1 Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн буцаан олголтыг журмын дагуу гүйцэтгэж байна уу?

2.2 Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байна уу?

3. Төв, орон нутгийн захиргаа, мэргэжлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг хэрэгжсэн эсэх

3.1 Орон нутгийн захиргаа болон мэргэжлийн байгууллагууд хуульд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу?

3.2 Хайгуулын болон тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн аж ахуйн нэгж, байгууллагууд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг үнэн зөв гаргаж, хянуулж байна уу?

3.3 Нөхөн сэргээлтийн ажил үр дүнтэй гүйцэтгэгдэж, түүнд тавих хяналт үр дүнтэй байна уу?

Дөрөв. Илрүүлсэн зөрчил
Тав. Аудитын дүгнэлт
Зургаа. Зөвлөмж
Долоо. Хавсралтууд

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОУБ	Байгаль орчны улсын байцаагч
БОНХАЖЯ	Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс

Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтүүд

1. Аудитын нэр:

Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн.

2. Аудитын код:

ҮАГ-ГАГ/2015/05-ГА-СЭА-2015/06-ГА

3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2015 оны 20-р тогтоол, МУ-ын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2015 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

4. Аудитын зорилт:

Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнг шалган үнэлгээ дүгнэлт, зөвлөмж өгч дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд гүйцэтгэлийн аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд асуудлын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

- Уул уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу тооцож төвлөрүүлсэн эсэх.
- Төвлөрүүлсэн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу зарцуулсан эсэх.
- Төв орон нутгийн захиргаа, мэргэжлийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг хэрэгжиж буй эсэх.

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитад Сэлэнгэ аймгийн 2013-2014 оны уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнгийн биелэлтийг хариуцсан орон нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагуудын /Аймгийн ЗДТГ, ИТХ, БОАЖГ, МХГ, Сумдын ЗДТГ ба бусад/ тайлант жилүүдэд хэрэгжүүлсэн арга хэмжээ, хамтын ажиллагаа, шийдвэр гаргалт, тэдгээрийн үр нөлөө, хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээ ажлын баримт материал, ашиг малтмалын хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж байгууллагуудын байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүнийн хэрэгжилтийн тайлан, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгө, түүний зарцуулалтын баримтуудыг хамруулан шалгалаа.

6. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан төрийн байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу шаардлагатай нотлох зүйлс цуглуулж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж, боловсруулав.

7. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитын явцад Уул, уурхай, ашигт малтмал, байгаль орчны үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжуудыг шалгуур үзүүлэлт болгохоос гадна, батлагдсан төсөв, гүйцэтгэл, тайлагнал зэрэг үзүүлэлтийг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Монгол улсын үндсэн хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам
- Уул уурхайн нөхөн сэргээлттэй холбоотой стандартууд.

8. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, аудитор Б.Эрдэнэзул нар 2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Хоёр. Үндсэн мэдээлэл

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2015 оны 6-р сарын байдлаар нийт 141.9 мянган га талбайд уул уурхайн салбарын 176 тусгай зөвшөөрөл олгогдсон бөгөөд үүний 58 нь хайгуулын, 118 нь ашиглалтын тусгай зөвшөөрөл байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн 86 нь алтны, 1 нь зэсийн, 2 нь нүүрсний, 9 нь төмрийн хүдрийн, 20 нь барилгын материал олборлох зөвшөөрөл байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд олгогдсон, хүчин төгөлдөр хэрэгжиж буй тусгай зөвшөөрөл

/2015 оны 06-р сарын 01-ний өдрийн байдлаар/

Хүснэгт-1

д/д	Сум	Бүгд		ашиглалт		хайгуул	
		Тусгай зөвшөөрлийн тоо	талбайн хэмжээ	Тусгай зөвшөөрлийн тоо	талбайн хэмжээ	Тусгай зөвшөөрлийн тоо	талбайн хэмжээ
1	Баянгол сум	34	18237.2	23	4938.74	11	13298.46
2	Ерөө	43	39720.01	30	5583.07	13	34136.94
3	Жавхлант	2	6197.01	0		2	6197.01
4	Мандал	25	18332.68	20	11190.42	5	7142.26
5	Орхон	7	1895.21	6	336.62	1	1558.59
6	Орхонтуул	24	26746.61	10	3305.09	14	23441.52
7	Сайхан	12	674.86	11	625.79	1	49.07
8	Сант	1	1292.42	0		1	1292.42
9	Түшиг	9	17405.7	5	3030.74	4	14374.96
10	Хүдэр	17	11271.59	12	3311.6	5	7959.99
11	Шаамар	2	132.14	1	25.56	1	106.58
	Нийт	176	141905.43	118	32347.63	58	109557.8

Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн салбарт томоохонд тооцогдох Бороогоулд” ХХК-ий Бороогийн алтны уурхай, “Болд төмөр ерөө гол” ХХК-ий Баянголын төмрийн хүдрийн уурхай, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ий Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай, Редхилмонголия” ХХК-ий Улаан-овоогийн нүүрсний уурхайнууд ашиглалтын үйл ажиллагаа явуулсан байна.

Гурав. Аудитын дүн

БҮЛЭГ 1

Уул, уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу тооцож төвлөрүүлсэн эсэх

Хайгуулын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс нөхөн сэргээлтийн баталгааны барьцаа хөрөнгийг бүрэн төвлөрүүлээгүй байна.

1.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах зардлыг журамд заасан хувь хэмжээгээр үнэн зөв тооцож байна уу?

Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүдийн дийлэнх нь нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах зардлыг журмын дагуу тооцсон байна.

МУ-ын Ашигт малтмалын тухай хуулийн 39.1.1 дэхь “... ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд уг зөвшөөрөл авсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах үүрэг хүлээнэ” гэсэн заалт болон БОАЖС-ын 2011 оны А-36 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам”, БОНХС-ын 2014 оны А-05 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2013 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч 11 аж ахуйн нэгж, 2014 онд 8 аж ахуйн нэгж байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулан Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан байна. /Хүснэгт 2 /

Аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах зардлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-2

Тусгай зөвшөөрөл эзэмшигч	2013 онд батлагдсан төсөв /мян.төг/	2014 онд батлагдсан төсөв /мян.төг/
“Бороогоулд” ХХК	407,100.0	1,008,754.4
“Сонортрейд” ХХК	6,000.0	26,300.0

“Болдтөмөр ерөө гол” ХХК	62,899.5	126,580.5
“Инфинитиспэйс” ХХК	18,970.0	55,453.0
Пураам” ХХК	3,230.0	0
Цемент шохой / 12219, 15249/	12,000.0	7,140.0
Хурай	11,256.0	18,712.6
Рэдхилмонголия	80,000.0	0
Эрдэсгрупп	9,752.0	0
Дарханы төмөрлөгийн үйлдвэр	80,000.0	100,000.0
Шижирталст	10,666.0	77,893.7
Нийт	710,122.5	1,420,834.2

Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу *хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч* нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах, уг төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сумын Засаг даргад хүргүүлж батлуулах үүрэг хүлээсэн байдаг. Үүний дагуу 2013 онд 37, 2014 онд 30 аж ахуйн нэгжүүд байгаль хамгаалах төлөвлөгөө боловсруулж сумдын Засаг даргаар батлуулсан байна. */Дэлгэрэнгүйг Хавсралт 1.1, 1.2-т үзүүлэв/*

Аудитын явцад хайгуулын үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдүүдийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль хамгаалах ажилд зарцуулахаар тусгасан зардлын судалгааг түүвэрлэн үзэхэд 2013 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч 14 аж ахуйн нэгж тус бүр хайгуулын ажлын цар хүрээнээс хамааран 2,00.0-1,000.0 мянган төгрөгийн хооронд нийт 8,040.0 мянган төгрөг, 2014 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч 17 аж ахуйн нэгж тус бүр 1,00.0-2,000.0 мянган төгрөгийн хооронд нийт 10,450.0 мянган төгрөг тусгасан байна. */Хавсралт-2 /*

Мөн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим хуулийн этгээдүүд байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөндөө байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулагдах зардлын тооцооллыг хийгээгүй байна. Үүнд: */Жавхлант сумын нутагт хайгуул хийсэн “Скэйнтгоулд” ХХК 2013 оны, Орхонтуул сумын нутагт хайгуул хийсэн “Өсөх хүч” ХХК 2013, 2014 оны, “Их Шижир Эрдэнэ” ХХК 2013 оны, Орхон сумын нутагт хайгуул хийсэн “Эм юу Ар Си” ХХК 2013 оны байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөнд/*

Иймд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүдийн байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөг баталгаажуулахдаа нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах зардлын тооцооллыг тусгуулж байх шаардлагатай байна.

1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүдээс нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг бүрэн төвлөрүүлж байна уу?

Хайгуулын үйл ажиллагаа явуулсан аж ахуй нэгжүүдээс байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулагдах барьцаа хөрөнгийг бүрэн төвлөрүүлээгүй байна.

МУ-ын Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.8, Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9, 9.10 дахь заалтууд болон Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 тоот

тушаалаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 2.3.1, 2.3.2-д заасны дагуу ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардлын 50 хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны болон сумын Төрийн сангийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулах үүрэгтэй.

Дээрх хууль, журамд заасны дагуу Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт ашиглалтын үйл ажиллагаа явуулсан 8 аж ахуй нэгжээс 2013 онд **97,934.5 мянган төгрөг**, 2014 онд **439,987.3 мянган** төгрөгийг БОНХАЖЯ-ны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн тусгай дансанд төвлөрүүлжээ.

БОНХАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрсөн барьцаа хөрөнгийг аж ахуйн нэгж тус бүрээр харуулбал:

Хүснэгт-3

№	Сумын нэр	Аж ахуй нэгжийн нэр	2013 он /мян.төг/				2014 он /мян.төг/			
			тусгай дансанд төвлөрүүлэх ёстой дүн	Урьд онуудад байршуулсан барьцаа хөрөнгөөс суутган тооцуулсан.	төвлөрүүлсэн дүн	Зөрүү	тусгай дансанд төвлөрүүлэх ёстой дүн	Урьд онуудад байршуулсан барьцаа хөрөнгөөс суутган тооцуулсан.	төвлөрүүлсэн дүн	Зөрүү
1	Баянгол	Бороогоулд	203,550.0	203,550.0	0.0	0.0	504,377.2	203,550.0	300,827.2	0.0
2	Баянгол	Сонортрейд	3,000.0	0.0	3,000.0	0.0	13,150.0		13,150.0	0.0
3	Ерөө	Болдтөмөр ерөө гол	31,449.8	0.0	31,449.8	0.0	63,290.3	31,890.3	31,400.0	0.0
4	Ерөө	Инфинитиспэйс	9,485.0		9,485.0	0.0	27,726.5	19,985.0	7,740.0	1.5
5	Мандал	Пураам	1,615.0		0.0	1,615.0				0.0
6	Орхон, Сайхан	Цемент шохой	6,000.0	1,000.0	0.0	5,000.0	3,570.0	0.0	3,570.0	0.0
7	Орхонтуул	Хурай	5,628.0	5,628.0	0.0	0.0	9,356.3	5,900.0	3,456.3	0.0
8	Түшиг	Рэдхилмонг олия	40,000.0	26,000.0	14,000.0	0.0				0.0
9	Хүдэр	Эрдэсгрупп	4,876.0	4,876.0	0.0	0.0				0.0
10	Хүдэр	Дарханы төмөрлөгийн үйлдвэр	40,000.0	0	40,000.0	0.0	50,000.0	0.0	50,000.0	0.0
11	Шарынгол, Баянгол	Шижирталст	5,333.0	5,333.0	0.0	0.0	38,946.9	6,000.0	29,843.9	3,103.0
Нийт дүн			344,936.8	245,387.0	97,934.8	6,615.0	710,417.2	267,325.3	439,987.4	3,104.5

2013-2014 онуудад ашиглалтын үйл ажиллагаа явуулсан аж ахуй нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан бөгөөд төвлөрүүлбэл зохих хөрөнгийн хэмжээг БОНХАЖЯ-ны дансанд төвлөрүүлсэн дүнтэй харьцуулахад, Пураам, Шижир талст, Цемент шохой зэрэг ХХК-ууд нийт **9,718.0** мянган төгрөгийн нөхөн сэргээлтийн барьцааг дутуу төвлөрүүлсэн байна.

Бороогоулд, Болд төмөр Ерөө гол, Инфинитиспэйс, Эрдэс групп, Рэдхилмонголия, Шижирталст, Хурай, Цемент шохой зэрэг ХХК-ууд 2013, 2014 онд нөхөн сэргээлтийн барьцааг байршуулахдаа нийт **299,201.3 мянган** төгрөгийг урьд онуудад төвлөрүүлсэн боловч буцаан олголт хийгдээгүй үлдэгдлээсээ суутган тооцуулжээ.

Хайгуулын үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүд 2013 онд **7,533.0 мянган** төгрөг, 2014 онд **7,672.6 мянган** төгрөгийг орон нутгийн тусгай дансанд, БОНХАЖЯ-

ны дансанд 425.0 мянган төгрөгийг байршуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-4

Сумын нэр	Банкны нэр	Дансны нэр	Дансны дугаар	ТЗ эзэмшигчийн тоо	2013 он /мян.төг/	ТЗ эзэмшигчийн тоо	2014 он /мян.төг/
БОНХАЖЯ Баянгол	Төрийн сан	Нөхөн сэргээлтийн барьцаа		0	0	1	425.0
	Төрийн сан	Хог хаягдлын сан	130855402	0	0	2	700.0
	Төрийн сан	Сум хөгжүүлэх сан	130855401	4	1,743.0	0	
Мандал	Төрийн сан	байгаль хамгаалах сан	130455401	5	1,270.0	1	250.0
Жавхлант	Төрийн сан	Итгэлийн зээл	131555010	3	895.0		0
Орхон	Төрийн сан	Байгаль орчны албаны нэмэлт санхүүжилт	130513401	1	200.0	1	400.0
Орхонтуул	Төрийн сан	Байгаль орчны нэгдсэн сан	131013401	1	500.0	3	3,732.6
Ерөө	ХААН банк	Уул уурхайн нөхөн сэргээлт	5679001303	5	2,425	3	1,550.0
Түшиг	Төрийн сан	Орон нутгийн татвар	131600995	1	500.0	1	540.0
Хүдэр сум	Төрийн сан	Байгаль хамгаалах сан	131355402	1		1	500
Нийт дүн				21	7,533.0	13	8,097.6

Ашигт малтмалын газрын тайлангаас үзэхэд тус газарт Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгүүдээс 2013 онд 81 хайгуулын ажлын төлөвлөгөө, 51 хайгуулын ажлын тайлан, 2014 онд 39 хайгуулын ажлын төлөвлөгөө, 29 хайгуулын ажлын тайлан хянагдсан байхад аудитын явцад сумдаас авсан судалгаагаар 2013 онд 37, 2014 онд 30 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөө батлуулсан байна.

Гэвч орон нутгийн нөхөн сэргээлтийн барьцааны дансанд 2013 онд 21, 2014 онд 12 аж ахуйн нэгж барьцаа хөрөнгө байршуулсан байна. Энэ нь нэг талаас хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд нь хууль, журамд заасан үүргээ хэрэгжүүлээгүй, нөгөө талаас сум, орон нутгийн төр захиргааны байгууллагууд, байгаль орчны улсын байцаагчийн зүгээс тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас шалтгаалж байна гэж дүгнэж байна. /Судалгааг хавсралт-1.1, 1.2-т үзүүлэв/

Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг Баянгол сум хог хаягдлын сан болон сум хөгжүүлэх сангийн, Жавхлант сум иргэдэд олгодог итгэлийн зээлийн, Түшиг, Орхон сум орон нутгийн орлогын дансанд, Ерөө сум арилжааны банкинд данс нээж тус тус байршуулсан нь МУ-ын Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчихөд хүргэж байна.

Аудитын явцад орон нутагт нь уул уурхайн ашиглалтын болон хайгуулын үйл ажиллагаа явуулж буй сумдын Засаг дарга, Байгаль орчны мэргэжилтэн, БОУБ нараас холбогдох баримт материалуудыг татан авч шалгахад суманд дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлээгүй, хайгуулд өртөгдсөн талбайн нөхөн сэргээлтийг актаар хүлээн авч баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нийтлэг байдлаар оршиж байна.

Мөн Баянгол, Ерөө, Мандал, Шаамар, Орхонтуул зэрэг сумдууд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг бүрэн төвлөрүүлээгүй бол Орхонтуул, Ерөө,

Шаамар, Түшиг зэрэг сумдууд аж ахуйн нэгжүүдийн төлөвлөгөө, тайланг журмын дагуу архивын нэгж болгон хадгалаагүй байлаа.

Дээрх байдлаас үндэслэн сум, орон нутгийн удирдлагууд МУ-ын Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3¹-д заасан эрх, үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна гэж дүгнэж байна.

Үүнээс шалтгаалан хайгуулын үйл ажиллагаа явуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль хамгаалах ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлантай бүрэн танилцах боломж бүрдээгүй болно.

Цаашид хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг бүрэн баталж, үйл ажиллагаанд хяналт тавих, нөхөн сэргээлийн барьцаа хөрөнгийг төрийн санд тусгай данс нээж байршуулах нь зүйтэй юм.

БҮЛЭГ 2

Төвлөрүүлсэн хөрөнгийг холбогдох хууль, журамд заасны дагуу зарцуулсан эсэх

Орон нутгийн дансанд төвлөрсөн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

2.1 Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн буцаан олголтыг журмын дагуу гүйцэтгэж байна уу?

Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн буцаан олголт журмын дагуу олгогдоогүй байна.

Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулсан 8 аж ахуйн нэгжүүдээс нөхөн сэргээлтийн барьцааны дансанд 2013, 2014 онуудад нийт **537,921.8 мянган** төгрөг байршуулсан байна.

Эдгээрээс “Бороогоулд” ХХК нь байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хүрээлэн буй орчинд хяналт шинжилгээ хийх зэрэг ажлуудыг бүрэн гүйцэтгэж холбогдох хууль, журмын дагуу 2013 онд 62,650.0 мянган төгрөгийн буцаан олголтыг бэлнээр авсан байна.

Дараах аж ахуй нэгжүүд урьд онуудад төвлөрүүлсэн нөхөн сэргээлтийн барьцааг тайлант онд шилжүүлэх хэлбэрээр суутган тооцуулжээ. Үүнд:

Бороогоулд” ХХК 2013, 2014 онуудад 203,550.0 мянган төгрөг, “Болд төмөр ерөө гол” ХХК 2014 онд 31,890.5 мянган төгрөг, “Инфинити спэйс” ХХК 2014 онд 19,987.0 мянган төгрөг, “Эрдэс групп” ХХК 2013 онд 4,876.0 мянган төгрөг, “Рэдхилмонголия” ХХК 2013 онд 2,6000.0 мянган төгрөг, “Шижирталст” ХХК 2014 онд 6,000.0 мянган төгрөг, “Хурай” ХХК 2013, 2014 онуудад 5,900.0 мянган төгрөгийг тус тус суутган тооцуулсан байна. /Дэлгэрэнгүйг хүснэгт 3-аас үзнэ үү /

БОНХАЖЯ нь дээрх аж ахуй нэгжүүдийн 2014 онд байршуулах ёстой нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дүнгээс урьд оны төвлөрүүлсэн хөрөнгийн дүнгээр суутган тооцохдоо Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 тоот

¹ 12.1.3 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих:

тушаалаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын хавсралтад заагдсан хяналтын хуудсаар хянаж баталгаажуулаагүй байгаа нь уг журмын 5 дугаар зүйлийн 5.1 дэхь” Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг буцаан олгохдоо энэ журмын хавсралтад заасан хяналтын хуудсыг баримтлана” гэсэн заалтыг зөрчихөд хүргэж байна.

Дээрх байдлаас үндэслэн нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэн аймгийн комисст актаар хүлээлгэн өгсөн аж ахуйн нэгжүүдэд тайлант жилд багтаан буцаан олголтыг бэлнээр олгоогүй, дараа оны төвлөрүүлэлтэд суутган тооцохдоо зөрүүгээр нь бус өмнөх оны бүх төвлөрүүлсэн дүнгээр тооцох зэргээр буцаан олголтыг холбогдох хууль журмын дагуу гүйцэтгээгүй байна гэж дүгнэж байна.

Иймээс ашиглалтын нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг БОНХАЖЯ-нд бус тухайн сум орон нутагт төвлөрүүлж, нөхөн сэргээлтийн ажилд тавих хяналтыг сайжруулах, буцаан олголтыг бодит гүйцэтгэлд үндэслэн тухайн тайлант жилд багтаан олгох замаар эдийн засгийн эргэлтэд оруулан үр өгөөжийг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хайгуулын үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдээс 2013-2014 онуудад нөхөн сэргээлтийн барьцаа болох нийт **15,005.6 мянган** төгрөгийг сум, орон нутгийн дансдад төвлөрүүлсэн боловч уг орлогоос тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд буцаан олголт огт хийгдээгүй байна. Өөрөөр хэлбэл, нэг талаас тухайн жил хайгуул хийгдсэн боловч дараа жил үргэлжлүүлэн хийх шаардлагын улмаас гаргасан цооногоо булалгүйгээр түр зуур таглаж битүүлдэг учир нөхөн сэргээх боломжгүй байдаг, нөгөө талаас сум орон нутгийн удирдлага, байгаль орчны улсын байцаагчид хайгуулд өртөгдсөн талбайг хариуцагч аж ахуйн нэгжүүд болон мэргэжлийн байгууллагаар нөхөн сэргээлт хийлгэж хүлээн авдаггүй, хяналт тавьдаггүй зэргээс төвлөрсөн хөрөнгийг буцаан олгоогүй байна.

2.2 Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байна уу?

Хайгуулын үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдүүдээс барьцааны дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг нөхөн сэргээлтийн арга хэмжээнд зарцуулаагүй байна.

Хайгуулын үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдээс 2013-2014 онд орон нутгийн дансанд байршуулсан нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн зарцуулалтыг аудитын явцад шалгаж, тулган баталгаажуулахад Баянгол, Мандал сумдууд төвлөрсөн хөрөнгийг ямар нэгэн үйл ажиллагаанд зарцуулаагүй бөгөөд дансны үлдэгдлээр байршиж байгаа бол Орхон, Түшиг сумдууд орон нутгийн татварын орлогын дансанд төвлөрүүлэн хуваарилах, Орхонтуул, Жавхлант, Ерөө сумдууд байгаль орчны чиглэлийн үйл ажиллагаанаас гадна хог цэвэрлэх, хувь хүнд зээл олгох, бөхийн тэмцээн, төсөвт байгууллагын урсгал засвар зэрэг тэс өөр, хөндлөнгийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд нийт **13,047.6 мянган** төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Сумын нэр	Зарцуулалтын утга	Мөнгөн дүн /мян.төг/	
		2013 он	2014 он
Ерөө	Чөлөөт бөхийн тэмцээний арга хэмжээнд.	1,000.0	
	Өргөдлийн дагуу иргэнд түр тооцоогоор зээлсэн боловч төлөгдөөгүй.	1,680.0	
	ЭМТ-ийн урсгал засварт	1,000.0	
	Сумын ерөнхий төлөвлөгөө хийлгэхэд	2,000.0	
	Сумын хөгжлийн санд түр тооцоогоор олгосон боловч эргэн төлөгдөөгүй.	600.0	
Жавхлант	Байгаль орчны албаны шатахуун, бусад зардалд	895.0	
Орхон	Орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлэн татварын орлогоор бүртгэсэн.	200.0	400.0
Түшиг		500.0	540.0
Орхонтуул	Хогны машины сэлбэгэнд	500.0	
	Сумын төвийн хог цэвэрлэгээний шатахуун, материалд		620.6
	Хогны машины засварт		1,781.1
	БОУБ, БХ нарын бичиг хэргийн материалын зардалд		235.0
	Кабелийн төлбөрт		114.0
	Хогийн цэгийн хог түрүүлэхэд шатахуун		396.8
	Хог цэвэрлэгээ түймэр, хяналт шалгалтын шатахуунд		585.07
Нийт дүн		8,375.0	4,672.6

Хайгуулын нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн тусгай дансанд байршуулах мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалтын тайланг жилийн эцэст сумын ИТХ-аар хэлэлцүүлж, дүнг Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлээгүй байна.

Дээрх зөрчлүүд нь 2014 оны 1 дүгээр сар хүртэл мөрдөгдөж байсан Байгаль орчны сайдын 2007 оны 6 дугаар тушаалаар батлагдсан “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүрэг биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 5.1, 5.4-дэхь заалт, 2014 оны 1 дүгээр сараас мөрдөгдөж эхэлсэн Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 4.1, 5.5-дахь заалтуудыг зөрчсөн байна.

Цаашид хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс төвлөрүүлж буй барьцаа хөрөнгийг төсөвт байгууллагуудын урсгал зардалд бус нөхөн сэргээлт, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулж, тайланг сумын ИТХ-аар хэлэлцүүлж, дүнг холбогдох яаманд хүргүүлэх нь зүйтэй юм.

БҮЛЭГ 3

Төв, орон нутгийн захиргаа, мэргэжлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг хэрэгжсэн эсэх.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд болон аймаг орон нутгийн төр захиргаа, мэргэжлийн байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

3.1 Орон нутгийн захиргаа болон мэргэжлийн байгууллагууд хуульд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу ?

Сэлэнгэ аймгийн хэмжээнд хууль бус алт олборлох байдал газар авч, ойн санг сүйтгэх, газрын гүний усыг бохирдуулах зэрэг сөрөг үйл ажиллагааг таслан зогсоож чадахгүй байна

Аймгийн ИТХ нь МУ-ын Байгаль хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай хуульд заасан бүрэн эрхийн дагуу² 2007 оны 05 сарын 03-ны өдрийн 51 тоот тогтоолоор “Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн талаар баримтлах бодлого”-ыг баталсан бөгөөд 2014 оны 10-р сарын 08-ний өдрийн 51 тоот тогтоолоор уг бодлогын баримт бичгийг шинэчилэн найруулж баталсан байна. Гэвч уг гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн тайланг хэлэлцээгүй байна.

2013, 2014 онуудад аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, ТЕЗ-аас төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээ зэрэг баримт бичгүүдэд уул уурхайн ашиглалт, нөхөн сэргээлттэй холбоотой дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

- 2013 онд “Уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орсон газрыг тогтоож, олборлолт явуулж буй аж ахуйн нэгж болон мэргэжлийн байгууллагуудаар нөхөн сэргээх” ажлыг хийж гүйцэтгүүлэх журам боловсруулан хэрэгжүүлэх ажлыг аймгийн ЗДТГ-ын ХБХ болон аймгийн БОАЖГ хариуцан хэрэгжүүлэхээр,
- 2014 онд Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд тогтмол хяналт тавьж, нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгүүлэх,
- Аймгийн хэмжээнд бичил уурхай эрхлэгчдийн судалгааг гарган, тэдгээрийг нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулах ажлуудыг тусган, аймаг, сумдын ЗДТГ, аймгийн БОАЖГ хариуцан хэрэгжүүлэхээр тус тус баталжээ.

Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудын хийсэн ажлын тайлан, баримт материалыг үндэслэн дүн шинжилгээ хийж үзэхэд:

- Аймгийн хэмжээнд уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орж орхигдсон газрын судалгаа гаргаагүй, мэдээллийн сан бүрдүүлж шинэчилсэн бүртгэл хөтлөөгүй байна.
- Олборлолт явуулж буй аж ахуйн нэгж болон мэргэжлийн байгууллагуудаар нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгүүлэх журам боловсруулаагүй байна.

² МУ-ын Байгаль хамгаалах тухай хуулийн 16.1.1 “нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүнийг баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;”

МУ-ын Ашигт малтмалын тухай хуулийн 12.1.3 “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;”

- Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд тодорхой хэмжээгээр хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй байна.
- Аймгийн хэмжээнд бичил уурхай эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлээгүй, шинэчилж бүртгээгүй байна.

Сэлэнгэ аймагт уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орж орхигдсон газрын тооллогыг 2010 онд БОАЖЯ-ы захиалгаар Шинжлэх ухааны академийн геологийн хүрээлэнгээр хийлгэсэн бөгөөд Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд уул уурхайн олборлолтын улмаас 16 аж ахуйн нэгжийн 30 нэгж талбар бүхий нийт 1181.42 га талбай /Баянгол суманд 28.52 га талбай, Хүдэр суманд 17.5 га талбай, Ерөө суманд 1135.4 га талбай тус тус орхигдсон/, гар аргаар алт олборлогчид (нинжа)-ын улмаас 57 га талбай тус тус эвдрэлд орж орхигдсныг бүртгэж, фото зургаар баримтжуулжээ.

2013 онд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон талбайд орон нутгийн төсвийн хөрөнгөөр нөхөн сэргээлт хийлгэхээр 100 га талбайн судалгааг гаргаснаас өөрөөр аймгийн хэмжээнд уул уурхайн улмаас эвдэрсэн, орхигдсон газрын талаар нэгдсэн судалгаа хийгээгүй, мэдээллийн сан бүрдүүлж шинэчлэн бүртгээгүй байна.

Аудитын явцад сумдад уул уурхайн ашиглалт, хайгуулын улмаас эвдэрч, нөхөн сэргээгдээгүй орхигдсон газруудыг судалсан байдлыг авч үзэхэд Баянгол, Ерөө, Мандал, Орхонтуул, Хүдэр сумдад нийт 598.2 га газрыг бүртгэсэн бол Шаамар, Орхон, Жавхлант, Сайхан, Сант, Түшиг сумдад эвдэрсэн газар байхгүй гэсэн дүн мэдээ гарсан байна. /Дэлгэрэнгүй судалгаа хавсралт-3/

Эвдэрсэн бөгөөд нөхөн сэргээгдээгүй газрын судалгаа

Хүснэгт-5			
д/д	Сумын нэр	Талбай /га/	Тайлбар
1	Баянгол	40.2	
2	Ерөө	469.0	
3	Мандал	44.0	
4	Орхонтуул	11.7	
5	Хүдэр	33.3	
6	Шаамар		эвдэрсэн газар байхгүй
7	Орхон		эвдэрсэн газар байхгүй
8	Жавхлант		эвдэрсэн газар байхгүй
9	Сайхан		эвдэрсэн газар байхгүй
10	Сант		эвдэрсэн газар байхгүй
11	Түшиг		эвдэрсэн газар байхгүй
Нийт дүн		598.2	

Цаашид аймгийн хэмжээнд уул уурхайн улмаас эвдэрсэн, орхигдсон газрын судалгааг гарган мэдээллийн сан үүсгэх, орсон өөрчлөлтөд тухай бүр хяналт тавьж мэдээллийн санг баяжуулан бүртгэж байх шаардлагатай байна.

Аймгийн ИТХ-ын 2007 оны 39 тоот тогтоолоор “Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахад

баримтлах журам"-ыг баталсан бөгөөд олборлолт явуулж буй аж ахуйн нэгж болон мэргэжлийн байгууллагуудаар нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгүүлэх журам боловсруулахаар төлөвлөсөн ч хэрэгжээгүй байна. Энэ талаар хэрэгжүүлэгч байгууллагуудаас тодруулахад аймгийн ЗДТГ-ын ХБХ энэ ажил хэрэгжээгүй гэсэн бол аймгийн БОАЖГ үйл ажиллагааны төлөвлөгөөндөө ч тусгаагүй байсан бөгөөд ямар зорилго ач холбогдолтой, ямар журам батлуулах байсан талаар мэдээлэлгүй байлаа.

Аймгийн ИТХ-аас байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих бүрэн эрхийн дагуу³ Хүдэр, Ерөө сумдад улсын үйлдвэрүүд ашиглаж байгаад орхигдсон газарт нөхөн сэргээлт хийлгэхээр 2013 онд 100 га талбайд 600,000.0 мянган төгрөгийн, 2014 онд 66 га талбайд 400,000.0 мянган төгрөгийн төсөв тус тус батлуулжээ.

Батлагдсан төсвийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, аймгийн БОАЖГ, Худалдан авах ажиллагааны албанаас техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан боловч 2013 онд аймгийн төсвийн орлого 15.4 хувиар буюу 2,802,148.7 мянган төгрөгөөр тасарсан, 2014 онд МУ-ын ЗГ-ын 2014 оны 291 тоот тогтоолоор улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авахаар төлөвлөсөн бараа, ажил, үйлчилгээний тендер зарлах, дүгнэх, гэрээ байгуулах ажлын санхүүжилтийг зогсоохыг тогтоосон зэрэг шалтгаанаар уг арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилт олгоогүй байна.

Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлыг МУ-ын Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар тогтоосон хувь хэмжээний дагуу⁴ тооцоолж үзэхэд 2013 онд 1,379,649.5 мянган төгрөг зарцуулахаар байтал 725,320.8 мянган төгрөг төлөвлөж 670,392.7 мянган төгрөг зарцуулсан бол 2014 онд 1,457,448.5 мянган төгрөг зарцуулахаар байтал 735,400.0 мянган төгрөг төлөвлөж 140,879.5 мянган төгрөг зарцуулсан⁵ байна.

Дээр дурдсанчлан холбогдох хуулийн дагуу уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд шаардлагатай зардлыг санхүүжүүлэхгүй байгаа нь аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлийн ажлууд хийгдэхгүй байх гол шалтгаан болж байна.

Сумдын төсөвт уул уурхайн улмаас эвдэрч, орхигдсон газарт нөхөн сэргээлт хийлгэх зардал батлагдаагүй байна.

2014 онд аймгийн хэмжээнд бичил уурхай эрхлэгчдийн судалгааг гарган, тэдгээрийг нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулах ажлуудыг аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ хариуцан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч тодорхой ажил хийгдээгүй байна.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг Засгийн газрын 2010 оны 308 тоот тогтоолоор баталж, мөн онд Газрын тухай хуульд бичил уурхайн зориулалтаар ашиглах газрыг тусгай хэрэгцээний газарт оруулахаар нэмэлт

³ МУ-ын Байгаль хамгаалах тухай хууль 16.1.1 нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэнд хяналт тавих;

⁴ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйл. **Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн хувь, хэмжээ**

⁵ Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2013, 2014 оны нэгдсэн санхүүгийн тайлангийн тоон мэдээллийг ашиглан тооцоолол хийв.

өөрчлөлт оруулснаар бичил уурхайн эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд хувиараа ашигт малтмал олборлогчдын байгаль орчинд ээлгүй, нийгмийн асуудал нь тогтворгүй, хариуцлагагүй, хууль бус уул уурхайн үйл ажиллагааг ил болгох, зүй зохистойгоор шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

Гэвч энэ нь бодит амьдралд хэрэгжих боломж бага байгаа бөгөөд бичил уурхайн зориулалтаар ашиглах газрыг тогтооход хүндрэл үүсдэг, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эдэлбэр газраас гурвалсан гэрээний үндсэн дээр бичил уурхай эрхлэгчдэд талбай, далд уурхай ашиглуулах нөхцөл бүрдээгүй, бичил уурхайн эрх зүйн орчин тодорхойгүй /бичил уурхай эрхлэгчид, орон нутгийн захиргааны байгууллага болон бусад байгууллагуудын оролцоо, эрх, үүрэг тодорхой бус/ зэргээс шалтгаалан өнөөг хүртэл хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулаагүй, аймгийн хэмжээнд нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж мэдээллийг шинэчлэн бүртгээгүй байгаа бөгөөд хувиараа ашигт малтмал олборлогчид хууль бус үйл ажиллагаа явуулсаар байна. Тодруулбал:

МУ-ын Үндэсний Статистикийн хорооноос 2012 онд улсын хэмжээнд бичил уурхай эрхлэгчдийн судалгаа хийсэн бөгөөд Сэлэнгэ аймагт нийт 1254 иргэн алт олборлож байгаагаас 20 хувь нь 10-аас дээш жил ажилласан, 564 иргэний 87.1 хувь нь тухайн орон нутагтаа татвар огт төлдөггүй гэсэн дүн гарч байсан байна. Үүнээс хойш аймгийн хэмжээнд бичил уурхай эрхлэгч, хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн болон үүний улмаас эвдрэлд орсон газрын нэгдсэн судалгаа хийгээгүй, шинэчилсэн мэдээллийн сан бүрдүүлээгүй байна.

Аймгийн БОАЖГ, АЗДТГ-ын ХБХ-ээс аймгийн бичил уурхай эрхлэгчдийн талаар бүрдүүлсэн мэдээллийг 2015 оны байдлаар авч үзэхэд Мандал суманд зохих зөвшөөрөлтэй 2 нөхөрлөлд 200 иргэн, Орхонтуул суманд зохих зөвшөөрлийг аваагүй 1 нөхөрлөлд 120 иргэн ажиллаж байгаа гэжээ.

Аудитын явцад сумдаас бичил уурхай эрхлэх зөвшөөрөлтэй, зөвшөөрөл аваагүй ч нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон байгууллага, иргэдийн судалгааг авч үзэхэд 4 суманд 95 нөхөрлөл, 865 иргэн хамрагдан бүртгүүлсэн бөгөөд Мандал суманд зохих зөвшөөрөлтэй 2 нөхөрлөлийн 200 иргэн үйл ажиллагаа явуулж байгаа бол Ерөө суманд хөндсөн, эзэн холбогдогч нь тодорхойгүй газруудад бүрэн ашиглалт явуулж, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийлгэхээр сумын ИТХ-аас тогтоол гарган 92 нөхөрлөл байгуулан, гэрээ хийн үйл ажиллагаа явуулж байна. Бусад сумдын нөхөрлөлүүд зохих зөвшөөрлийг аваагүйгээс үйл ажиллагаа явуулаагүй гэсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-6

д/д	Сумдын нэр	Албан ёсны зөвшөөрөлтэй эсэх	Ашиглаж байгаа талбайн хэмжээ /га/	Олборлолт эхэлсэн огноо	Ашигт малтмалын төрөл	Нөхөрлөлийн тоо	Гишүүдийн тоо	Олборлолт явуулж эхэлснээс хойш эвдрэлд орсон талбай /га/	Нөхөн сэргээлт хийсэн талбай /га/	Тайлбар
1	Мандал	Тийм	15,98	2012	Алт	2	200	1	1	Зохих зөвшөөрөлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа
2	Орхонтуул	Үгүй	0,7	2011	Алт	1	120	0,4	1	Үйл ажиллагаа явуулаагүй, өмнөх

									онуудад явуулж байсан
3	Баянгол	Үгүй			Алт		85		Үйл ажиллагаа явуулаагүй
4	Ерөө	Үгүй			Алт	92	460		2015 онд сумын Засаг даргатай гэрээ байгуулан олборлолт явуулж байгаа бөгөөд нөхөн сэргээлтийг хийлгэхээр ажиллаж байна.
Нийт дүн						95	865		

Ерөө сумын нутаг дэвсгэрт хариуцлагагүй уул уурхайн олборлолтын улмаас ойн сан бүхий талбай сүйдэгдсэн, хүн явах, мал бэлчих боломжгүй болсон, байгалийн унаган төрх алдагдсан, бэлчээрийн хомсдол бий болсон гэсэн шалтгаанаар эвдэрсэн газрыг дахин ашиглаж техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийлгэх талаар төлөөлөгч нараас гарсан саналыг үндэслэн сумын ИТХ-аас 2015 оны 06 сарын 15-ны өдрийн 70-р тогтоолоор 2 сарын хугацаатайгаар ашиглалт явуулж, нөхөн сэргээлт хийлгэх тухай гэрээг 92 нөхөрлөлтэй байгуулан үйл ажиллагаа явуулж байна.

Гэвч уг үйл ажиллагаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 4, 7, 35 дугаар зүйлийн, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг зөрчсөн үйлдэл болсон тул аймгийн БОАЖГ-аас тогтоолыг хүчингүй болгох албан бичиг, МХГ-аас хууль бус үйл ажиллагааг зогсоох шийдвэрийг тус тус хүргүүлсэн боловч хэрэгжүүлээгүй байна.

Бид аудитын явцад Хүдэр сумын Хүдэр гол нэртэй газарт алт олборлож буй байдалтай танилцахад Монгол алт компани 2000–аад оны эхээр олборлолт хийж байгаад нөхөн сэргээлт хийгээгүй орхигдсон талбайд аж ахуйн нэгж, хувь иргэд нь мэдэгдэхгүй хүмүүс иж бүрэн техник ашиглан олборлолт хийж, алтыг ялган угааж байсан бөгөөд ашиглалт явуулах тусгай зөвшөөрлөө үзүүлэхийг шаардахад захирал, эзэд нь байхгүй, бид мэдэхгүй гэж хариулж байлаа. Алтны олборлолт явуулж буй эдгээр талбай нь ойн санд тулсан бөгөөд ой модыг илт сүйтгэсэн, газрын гүний усыг гартал олборлолт явуулж бохирдуулсан байдал харагдаж байв.



Хүдэр суманд хууль бус олборлолт явуулж буй газрын байдал



“ДБТХ” компани нь ойн санд тулж олборлолт явуулж буй байдал

Тус газар үйл ажиллагаа явуулж буй “ДБТХ” ХХК-ний тусгай зөвшөөрөл бүхий талбай нь ойн санд тулсан боловч олборлолт явуулсаар байгаа бөгөөд ашигласан талбайг тэгшилж хэлбэршүүлэн техникийн нөхөн сэргээлтийг гүйцэтгэж байв.



“ ДБТХ “ компаний техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал

Дээрх хууль бус үйлдлийн талаар Хүдэр сумын Засаг дарга, Ойн ангийн дарга нараас тодруулга авахад:

- ✓ Сумын засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан холбогдох хуулийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалтыг гүйцэтгэж техникийн компьютерийг хураах, лацдаж үйл ажиллагааг нь зогсоох зэрэг арга хэмжээ авдаг боловч явсан хойгуур дахин олборлолт явуулдаг,
- ✓ Хууль бусаар алт олборлогч иргэд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоох хүн хүч хүрдэггүй, аймгийн хууль хяналт, цагдаа, тагнуул зэрэг хүчний байгууллагууд ч дийлдэггүй байдалд хүрсэн гэж нүдэн дээр илт зөрчлүүдтэй эвлэрсэн, хүлээн зөвшөөрсөн байдал ажиглагдаж байлаа.

Мандал сумын 4-р багийн нутаг Ноён уулын орчимд 2015 оны 1-р сараас эхлэн өнөөг хүртэл хууль бусаар алт олборлогчид үйл ажиллагаа явуулсаар байна. Сумын ЗТДГ, Байгаль орчны хяналтын тасаг, Сум дундын цагдаагийн хэлтэс хамтран хууль бус үйлдлийг таслан зогсоох, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж, давхардсан тоогоор 600 орчим тээврийн хэрэгсэл бүхий 2000 гаруй иргэдийг албадан тараах арга хэмжээг авсан хэдий ч дээрх хууль бус үйлдэл бүрэн зогсоогүй байна.

Аймгийн МХГ-ын болон байгаль орчны байцаагч нарын тайлан, мэдээнээс үзэхэд Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтээр сумдын ЗДТГ-тай хамтран 2013 онд 19 удаа, 2014 онд 14 удаа хяналт шалгалт хийж 2013 онд 6, 2014 онд 21 аж ахуйн нэгж, иргэнтэй холбоотой зөрчилд арга хэмжээ авсан бол 2015 он гарсаар Засгийн газрын “1111 төв”-д ирсэн санал, гомдлын дагуу 2 удаагийн шалгалтыг хамтран гүйцэтгэж 16 ААН, иргэнтэй холбоотой зөрчил илрүүлсэн байна. /Хавсралт-4 /

Хэдийгээр зөрчил гаргасан аж ахуй нэгжүүдийн техникийг лацдаж, зарим тоног төхөөрөмж, металлыг хурааж үйл ажиллагааг нь зогсоодог ч аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулдаг байна. Тухайлбал Ерөө суманд “Ди Зэт Энд” ХХК, Хүдэр суманд “Зүб” гол ХХК, “Халнит” ХХК-иуд тусгай зөвшөөрөлтэй ч зохих баримтгүйгээр үйл ажиллагаа явуулж байсан бол ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй, хууль бусаар Орхонтуул суманд “Жааз прогресс” ХХК, Хүдэр суманд “Золотая корона” ХХК, “Хүдэр Хаан” ХХК, “Топ Маунтайн” ХХК, Ерөө суманд “Бронзикеистл” ХХК, “Баянсуут” ХХК, “Сидар” ХХК зэрэг компаниуд давтан шалгалтаар олборлолт хийж байжээ.

Аймгийн БОАЖГ-аас Хүдэр суманд хууль бусаар алтны олборлолт явуулж байсан “Бүүргэнэт” ХХК, “Үржил нутаг” ХХК, С.Төмөрбаатар, “ДБТХ” ХХК, “Азын хишиг” ХХК, “Зүбгол” ХХК, “Халнит” ХХК, “Топ Маунтайн” ХХК зэрэг аж ахуй нэгжүүдийг үйлдлийг баримтжуулан дүрс бичлэг хийж БОНХАЖЯ, аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газруудад зохих арга хэмжээ авахыг хүссэн албан тоот явуулсан боловч ямар ч арга хэмжээ аваагүй бөгөөд хууль бус алт олборлолтыг үргэлжлүүлэн явуулсаар байна.

Дээрх байдлуудаас үндэслэн Сэлэнгэ аймгийн хэмжээнд хууль бус алт олборлох байдал газар авч ойн санг сүйтгэх, газрын гүний усыг бохирдуулах зэрэг сөрөг үйл ажиллагааг таслан зогсоож чадахгүй байна гэж дүгнэж байна.

3.2 Хайгуулын болон тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжүүд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг үнэн зөв гаргаж, хянуулж байна уу?

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд нь байгаль хамгаалах болон хайгуулын ажлын төлөвөгөө, биелэлтийн тайлан зэргийг орон нутгийн захиргааны байгууллагуудад ирүүлэхгүй байгаа нь тэдний зүгээс тавих хяналтыг сулруулж байна.

Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан баталгаажуулах, тайлагнахдаа холбогдох хуулиудаас гадна 2013 онд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2011 оны 02 сарын 16-ны өдрийн А-36 дугаар тушаалаар

батлагдсан журам⁶, 2014 онд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-05 дугаар тушаалаар батлагдсан журмыг⁷ тус тус баримтлахаар зохицуулагджээ.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОНХЯ, Ашигт малтмалын газар, МХЕГ-уудаар хянан баталгаажуулж, аймгийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудаар шаардлагатай төлөвлөгөө, гэрээнүүдийг батлуулснаар үйл ажиллагаа явуулах эрх үүсдэг бөгөөд биелэлтийн тайланг МХЕГ, Ашигт малтмалын газарт хянуулдаг байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн хайгуулын ажлын төлөвлөгөөг Ашигт малтмалын газар, МХЕГ-аар, байгаль хамгаалах төлөвлөгөөг сумын Засаг даргаар тус тус хянуулж батлуулснаар үйл ажиллагаа явуулах эрх үүсдэг бөгөөд биелэлтийн тайланг Ашигт малтмалын газарт хүргүүлэхээр зохицуулагдсан байдаг.

Гэвч тусгай зөвшөөрөл эзэмшигч ихэнх аж ахуйн нэгжүүд төлөвлөгөө, тайлангийн хуулбарыг тухайн ашигт малтмалын орд байршиж байгаа нутаг дэвсгэрийг харьяалах аймаг, сумын Засаг дарга болон байгаль орчны хяналтын албанд хүргүүлээгүй байна. /Хавсралт-5.1, 5.2/

Ашигт малтмалын газар, аймгийн БОАЖГ, сумдаас авсан тайлан, мэдээ, анхан шатны баримтаас үзэхэд 2013 онд 20 аж ахуйн нэгж хайгуулын ажлын болон байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө батлуулснаас аймаг, сумдын захиргааны байгууллагуудад 9 аж ахуйн нэгж менежментийн төлөвлөгөө, 6 аж ахуйн нэгж биелэлтийн тайлан ирүүлсэн бол 2014 онд 14 аж ахуйн нэгж төлөвлөгөө батлуулснаас 6 аж ахуй нэгж төлөвлөгөө, 5 аж ахуй нэгж биелэлтийн тайлангаа ирүүлжээ.

2013 онд Ашигт малтмалын газарт хайгуулын үйл ажиллагаа явуулахаар 81 аж ахуйн нэгж хайгуулын ажлын төлөвлөгөө батлуулж 53 биелэлтийн тайлан хүргүүлсэн байтал сумын захиргааны байгууллагад 5 хайгуулын ажлын төлөвлөгөө, 16 байгаль хамгаалах төлөвлөгөө ирүүлж биелэлтийн тайлан огт ирүүлээгүй бол 2014 онд Ашигт малтмалын газарт 39 төлөвлөгөө, 29 биелэлтийн тайлан хянуулж, батлуулсан байтал орон нутагт 6 хайгуулын ажлын төлөвлөгөө, 18 байгаль хамгаалах төлөвлөгөө, 3 биелэлтийн тайлан ирүүлсэн байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд нь байгаль орчны менежментийн болон хайгуулын төлөвлөгөө, биелэлтийн тайлан зэргийг тухайн орон нутгийн захиргааны байгууллагуудад ирүүлэхгүй байгаа нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхгүй байгаагаас⁸ гадна батлагдсан төлөвлөгөө, ажлын хуваарийн

⁶ "Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам"

⁷ "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"

⁸ МУ-ын ашигт малтмалын тухай хууль 38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг: 38.1.3.энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах; 38.1.4.энэ хуулийн 38.1.3-т заасны дагуу батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг хайгуулын талбай байршиж байгаа орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

39 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг 39.1.6.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдмагц тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тэдгээрийн хуулбарыг тухайн ашигт малтмалын орд байршиж байгаа нутаг дэвсгэрийг харьяалах аймаг, сум, дүүргийн Засаг дарга болон байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

дагуу үйл ажиллагаагаа явуулж буй эсэх, биелэлтийг үнэн зөвөөр тайлагнасан эсэхэд орон нутгийн зүгээс хяналт тавих нөхцлийг алдагдуулж байна.

Цаашид аймаг, сумдын орон нутгийн захиргааны байгууллагуудын зүгээс байгаль орчин, уул уурхай хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудтай төдийгүй өөр хоорондоо ажлын уялдаа холбоотой хамтран ажиллах, шаардлагатай тайлан мэдээг тухай бүр гаргуулан авч үйл ажиллагаатайгаа уялдуулан ажил үүргээ гүйцэтгэж байх шаардлагатай байна.

3.3 Нөхөн сэргээлтийн ажил үр дүнтэй гүйцэтгэгдэж, түүнд тавих хяналт үр нөлөөтэй байна уу?

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлтэд аймгийн МХГ, БОАЖГ-аас тодорхой хэмжээгээр хяналтыг хэрэгжүүлж байгаа ч хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн байгаль хамгаалах үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн арга хэмжээнд хэрхэн хяналт тавьж хэрэгжилтийг тооцдог нь тодорхойгүй байна.

Ашигт малтмалын газрын тайлан, аймаг, сумдаас авсан судалгаа, ирүүлсэн анхан шатны баримт материалаас үзэхэд 2013 онд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 20 аж ахуйн нэгж уулын ажлын төлөвлөгөө батлуулснаас 12 аж ахуйн нэгж 7.2 га-д техникийн, 93.3 га-д биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж 7 аж ахуйн нэгж 14.9 га-д техникийн, 76.5 га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.

2014 онд 14 аж ахуйн нэгж уулын ажлын төлөвлөгөө батлуулснаас 7 аж ахуйн нэгж 7.4 га-д техникийн, 68.7 га-д биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж 7.0 га-д техникийн, 65.9 га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн байна. /Хавсралт -6.1, 6.2/

Хүснэгт -7

Үзүүлэлт	Техникийн нөхөн сэргээлт			Биологийн нөхөн сэргээлт		
	Төлөв	Гүйц	Хувь	Төлөв	Гүйц	Хувь
2013 он	7.2	14.9	206.9	93.3	76.5	82.0
2014 он	7.4	7.0	94.6	68.7	65.9	95.9

Үүнээс харахад биологийн нөхөн сэргээлтийг төлөвлөснөөс 2013 онд 18.0 хувиар, 2014 онд 4.1 хувиар тус тус дутуу хийсэн байна. Нөхөн сэргээлт дутуу хийгдсэн шалтгаануудыг дурдвал:

1. Уулын ажилд хамруулахаар төлөвлөсөн талбайг бүрэн ашиглаагүй, үйл ажиллагаа явуулаагүй зэргээс дараах компаниуд нөхөн сэргээлтийг дутуу болон огт хийгээгүй байна. Үүнд:

48 дугаар зүйл. Мэдээ, тайлан гаргах 48.1.2.хайгуулын ажлын жилийн тайланг төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу гаргаж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор; 48.6.3.ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд нөөцийн зэрэглэлийг ахиулах ашиглалтын хайгуулыг тухай бүр хийж, ажлын төлөвлөгөө, тухайн жилийн болон хайгуулын ажлын үр дүнгийн тайланг энэ хуулийн 48.1.2-т заасны дагуу. 48.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

2013 онд

- Хурай ХХК нь 1.6 га талбайг ашиглахаар төлөвлөсөн ч 0.58 га талбайг ашигласан тул 0.3 га-д техникийн, 0.9 га-д биологийн нөхөн сэргээлт дутуу хийсэн,
- Шим констракшн ХХК нь үйл ажиллагаагаа бүрэн явуулаагүй тул төлөвлөсний дагуу 0,39 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгээгүй,
- Пураам ХХК 0.9 га талбайг ашиглахаар төлөвлөсөн ч 0.5 га талбайг ашигласан тул техникийн нөхөн сэргээлтийг төлөвлөснөөс 2 га талбайд илүү хийж, 8.9 га-д биологийн нөхөн сэргээлтийг хийгээгүй,
- Үйл ажиллагаа явуулаагүйгээс НАБД ХХК 2 га, Гангар харш ХХК 0,05 га талбайд нөхөн сэргээлт хийгээгүй байна.

2014 онд

- Хурай ХХК нь 1.6 га талбайг уулын ажилд хамруулахаар төлөвлөсөн ч 0.6 га талбайг ашигласантай холбоотойгоор 0.3 га-д техникийн, 0.9 га-д биологийн нөхөн сэргээлт дутуу хийсэн,
- Үйл ажиллагаа явуулаагүйгээс Эрдэс холдинг ХХК 5 га-д, Пураам ХХК 2 га-д техникийн, 8.9 га-д биологийн нөхөн сэргээлт тус тус хийгээгүй байна.
- Хурай ХХК нь уулын ажилд 33.6 мянган метр куб талбай ашиглахаас 25.0 мянган метр талбайг ашигласан тул 1.1 1.1 гад техникийн, 1 гад биологийн нөхөн сэргээлтийг хийгээгүй байна.

2. Менежментийн төлөвлөгөөнд нөхөн сэргээх ажлыг тусгасан ч дараах компаниуд хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Сонор трейд ХХК нь 2013 онд 0.1 га-д техникийн, 0.3 га-д биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн боловч хийгээгүй, 2014 онд төлөвлөсний дагуу талбайгаа бүрэн ашигласан боловч 0.4 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг дутуу хийсэн байна.
- Редхил Монголиа ХХК нь 2013 онд уулын ажлыг төлөвлөснөөс илүү талбайд явуулсан ч төлөвлөсөн 2 га талбайд нөхөн сэргээлт хийгээгүй байна.

2013, 2014 онуудад нөхөн сэргээлт хийсэн газрыг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2011 оны А-36 дугаар тушаалаар⁹ батлагдсан журам, маягтын дагуу хүлээн авч актаар баталгаажуулсан бол дүйцүүлэх нөхөн сэргээлтээр ойжуулалт хийсэн газруудыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 дугаар тушаалаар¹⁰ батлагдсан журам, маягтын дагуу хүлээн авч актаар баталгаажуулжээ.

⁹ “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам”

¹⁰ “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”

Гэвч дараах компаниуд нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн гэж тайлагнасан ч үүнийг нотлох анхан шатны баримт /ажил хүлээлгэн өгсөн акт/ байхгүй байна. Үүнд:

- 2013 онд Сонор трейд ХХК 0.02 га-д, Хурай ХХК 1 га-д, Пураам ХХК 4 га-д,
- 2014 онд Сонор трейд ХХК 0.7 га-д, Хурай ХХК 0.8 га-д, Даланбулаг трейд ХХК 0.5 га-д тус тус нөхөн сэргээлт хийсэн гэж тайлагнасан ч энэ нь нөхөн сэргээлтийг хүлээлгэн өгсөн актаар баталгаажуулж байлаа.

2013, 2014 онуудад менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлт хийсэн компаниудаас гадна дараах 6 аж ахуйн нэгж, бичил уурхайчид өөрсдийн хөрөнгөөр 20.7 га-д техникийн, 6.0 га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.

Хүснэгт-8

д/д	Компанийн нэр	Сумын нэр	Газрын нэр	Нөхөн сэргээлт хийсэн /га/		Тайлбар
				техникийн	биологийн	
2013 онд						
1	Ди Зэт энд Ай ХХК	Ерөө	Нарийний алтны орд, Толгойтын алтны үйлдвэрийн ил уурхай	3	3	Тусгай зөвшөөрөлтэй талбайдаа нөхөн сэргээлт хийж 13.11.10 өдөр хүлээлгэн өгч акт үйлдсэн
2	Монлидтрейд ХХК	Ерөө	Өлөнтийн ам	4		Тусгай зөвшөөрөлтэй талбайдаа нөхөн сэргээлт хийж 13.12.23 өдөр хүлээлгэн өгч акт үйлдсэн
2014 онд						
3	Толгойтын гол ХХК	Ерөө Бугант	Хайлаастын орд		3.0	Тусгай зөвшөөрлийн талбайдаа нөхөн сэргээлт хийж 14.10.16 өдөр хүлээлгэн өгч актаар баталгаажуулсан.
4	ДБТХ	Ерөө Бугант	Хайлаастын орд	12.9		Тусгай зөвшөөрөлтэй талбайдаа нөхөн сэргээлт хийсэн.
5	Бичил уурхайчид	Мандал	Ноёд уул	0.8		Сумын комисст хүлээлгэн өгсөн.
Нийт дүн				20.7	6.0	

Бид аудитын явцад Баянгол суманд ашиглалтын үйл ажиллагаа явуулсан Шижир талст ХХК, Бороо гоулд ХХК-иудын нөхөн сэргээлт хийсэн талбайтай танилцахад байгалийн унаган төрхийг сэргээж, ургамалжуулан, чацарганы мод тарьсан байсныг журмын дагуу хүлээлгэн өгч, актаар баталгаажуулсан байна.



“Шижир талст” ХХК-ний 2014 онд хийсэн нөхөн сэргээлт



“БТЕГ” ХХК-ний 2013, 2014 онд хийсэн нөхөн сэргээлт



Бороогоулд ХХК-ний 2013, 2014 онд хийсэн нөхөн сэргээлт

Мөн Ерөө сумын Болдтөмөр Ерөө гол ХХК нь 2013 онд 20 га талбайд дүйцүүлэн нөхөн сэргээлт хийснийг хүлээлгэн өгч, актаар баталгаажуулсан байлаа.

Харин Хүдэр суманд төмрийн хүдрийн олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-нь 2014 онд биологийн нөхөн сэргээлт хийх талбайг дур мэдэн сонгож, сумын байгаль орчны байцаагчтай аман тохиролцоогоор 20 га талбайд мод тарьсан нь иргэдийн өмчилсөн талбайтай давхацсан бөгөөд албан тушаалтнуудын хариуцлагагүй байдлаас шалтгаалан уг нөхөн сэргээлт үр дүнгүй болсон байна.

Хайгуулын үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн тайлан төлөвлөгөөтэй танилцахад ихэнх нь жижиг цооног өрөмдөн буцааж булдаг тул нөхөн сэргээлтийн зардал маш багаар тооцогддог, зарим нь өөрсдийн хүчээр дээрх ажлыг гүйцэтгэнэ гэсэн шалтгаанаар зардал тооцож батлуулдаггүй байна.

Аудитаар сумдын БОУБ нараас 2013, 2014 онуудад хайгуулын үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлтийг актаар хүлээн авч байгаа эсэх талаар тодруулга авахад Ерөө суманд хайгуулын үйл ажиллагаа явуулсан “Харангахүдэр” ХХК-нь 2013 онд 158 цооногийг бөглөж нөхөн сэргээлт хийн сумын комисст хүлээлгэн өгсөн акт үйлдсэн бол бусад хайгуул хийсэн аж ахуйн нэгжүүд

нөхөн сэргээлт хийж, албан ёсоор хүлээлгэн өгөөгүй байлаа. Өөрөөр хэлбэл хайгуулын үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүд нөхөн сэргээлт хийдэггүй бөгөөд тухайн сум, орон нутгийн зүгээс аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд тавих хяналт хангалтгүй байна.

Цаашид сум орон нутгийн холбогдох ажилтнууд нь үйл ажиллагаа явуулж буй хайгуулын ажлын төлөвлөгөө, байгаль хамгаалах төлөвлөгөөг архивын нэгж болгон хадгалах, мэдээллийн сангуудыг бүрдүүлэх, шинэчлэн бүртгэж байх замаар зохих хяналтуудыг үр дүнтэй, бодитой хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дөрөв. Илрүүлсэн зөрчил

Гүйцэтгэлийн аудитаар мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

1. Төлбөрийн акт:

- Ерөө сумын Төрийн сангийн төлөөлөгч А.Төгсжаргалд түр тооцоогоор зээлүүлсэн боловч эргэн төлөгдөөгүй 1,680.0 мянган төгрөг,
- Ерөө сум “ Сумын хөгжлийн сан”-д түр тооцоогоор олгосон 600.0 мянган төгрөг,
- Ерөө сум чөлөөт бөхийн тэмцээнд зарцуулсан 1,000.0 мянган төгрөг,
- Ерөө сум Эрүүл мэндийн төвийн урсгал засварт зарцуулсан 1,000.0 мянган төгрөг,
- Ерөө сум сумын ерөнхий төлөвлөгөө хийлгүүлэхэд 2,000.0 мянган төгрөг,
- Орхонтуул сум хогны машины засварт зарцуулсан 1,781.1 мянган төгрөг,
- Орхонтуул сум кабелийн шугамд зарцуулсан 114.0 мянган төгрөг зэрэг нийт **8,175.1 мянган** төгрөгийг нөхөн төлбөрийн тусгай дансанд шилжүүлж, зориулалтын дагуу зарцуулах.

2. Албан шаардлага :

- Хайгуулын үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдүүдээс орон нутгийн дансанд байршуулсан нөхөн сэргээлтийн барьцааг зориулалт бусаар зарцуулсан 4,872.5 мянган төгрөг,
- Ашиглалтын үйл ажиллагаа явуулсан 3 аж ахуйн нэгж БОНХАЖЯ-ны дансанд нөхөн сэргээлтийн барьцааг дутуу төвлөрүүлсэн 9,718.0 мянган төгрөг,
- Ерөө сумын Хаан банкин дахь 5679001303 тоот Уул уурхайн нөхөн сэргээлтийн барьцааны дансны үлдэгдэл 5,685.03 мянган төгрөгийг төрийн санд татан төвлөрүүлэх, зэрэг нийт 28,450.6 мянган төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага бичигдлээ.

Тав. Дүгнэлт

- Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим хуулийн этгээдүүд байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөндөө байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулагдах зардлын тооцооллыг хийгээгүй бөгөөд нөхөн сэргээлтийн баталгааны барьцаа хөрөнгийг бүрэн төвлөрүүлээгүй байна.
- Ашиглалтын нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг тайлант жилд багтаан бэлнээр буцаан олгохгүйгээр дараа жилийн барьцаа хөрөнгөд суутган тооцож холбогдох журмыг зөрчиж байна.
- Баянгол, Жавхлант, Түшиг, Орхон, Ерөө, Орхонтуул сумд хайгуулын нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг төрийн сан дахь тусгай дансанд бүрэн төвлөрүүлээгүй бөгөөд төвлөрсөн хөрөнгийг төсөвт байгууллагуудын урсгал зардалд зарцуулсан байна.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд нь байгаль орчны менежментийн болон хайгуулын төлөвлөгөө, биелэлтийн тайлан зэргийг тухайн орон нутгийн захиргааны байгууллагуудад бүрэн ирүүлэхгүй байна.
- Хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлээгүй, хайгуулд өртөгдсөн талбайн нөхөн сэргээлтийг актаар хүлээн авч баталгаажуулаагүй, аж ахуйн нэгжүүдийн төлөвлөгөө, тайланг журмын дагуу архивын нэгж болгон хадгалаагүй зэрэг зөрчлүүд сумдад нийтлэг байдлаар байдлаар оршиж байна.
- Сум, орон нутгийн төр захиргааны байгууллагууд, байгаль орчны улсын байцаагчийн зүгээс тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.
- Аймгийн хэмжээнд уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орж орхигдсон газар, бичил уурхай эрхлэгчид, хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн судалгаа, мэдээллийн сан бүрдүүлээгүй, шинэчилсэн бүртгэл хөтлөөгүй байна.
- Олборлолт явуулж буй аж ахуйн нэгж болон мэргэжлийн байгууллагуудаар нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгүүлэх журам боловсруулаагүй байна.
- Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд шаардлагатай зардлыг холбогдох хуулийн дагуу төлөвлөж, санхүүжүүлэхгүй байгаа нь аймгийн байгаль орчныг хамгаалах, орхигдсон газруудыг нөхөн сэргээх чиглэлийн ажлууд хийгдэхгүй байх гол шалтгаан болж байна.
- Биологийн нөхөн сэргээлтийг төлөвлөснөөс 2013 онд 18 хувиар, 2014 онд 4.1 хувиар тус тус дутуу хийсэн байна,
- Хайгуулын үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүд нөхөн сэргээлт хийхгүй байна.
- Аймаг, сумдын засаг захиргаа болон мэргэжлийн байгууллагуудын хяналт, шалгалтын үйл ажиллагаа үр нөлөөтэй хийгдэхгүй байгаагаас хууль бус алт олборлолт, ойн санг сүйтгэх, газрын гүний усыг бохирдуулах, нөхөн сэргээлт хийхгүй орхих зэрэг сөрөг үйл ажиллагааг таслан зогсоож чадахгүй байна.

Зургаа. Аудитын зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат, ЗДТГ-ын ХБХ-ийн дарга Ч.Дэмбэрэлсайхан нар-т

- Сэлэнгэ аймгийн хэмжээнд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагааны талаар нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, тэдгээрийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөө болон орчны хяналтын хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулах.
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлыг МУ-ын Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар тогтоосон хувь хэмжээгээр төлөвлөж, санхүүжүүлэх.
- Уул уурхайн олборлолтын улмаас эвдрэлд орж эзэнгүй орхигдсон талбай, бичил уурхай эрхлэгчид, хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн судалгаа гаргаж, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, цаашид улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар нөхөн сэргээлт хийж гүйцэтгүүлэх.
- Хувиараа, хууль бусаар алт олборлогчдын үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээг хууль, хяналт, хүчний байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, сүйтгэгдсэн талбайг нөхөн сэргээх.
- Уул уурхай хариуцсан төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлыг зохион байгуулах.

Аймгийн МХГ-ын дарга Д.Энхсайханд

- Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдүүдийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, илэрсэн зөрчлийг арилгуулах үүргийг сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллах.
- Хууль бусаар алт олборлож буй иргэд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээ авах, холбогдох дээд байгууллагад уламжлах, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх.

Аймгийн БОАЖГ-ын дарга Б.Батзоригт

- Аймгийн хэмжээнд ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө тайлан, уулын ажлын төлөвлөгөө, тайланг бүрэн хүлээн авч дүгнэж байх.
- Аймгийн хэмжээнд хайгуулын үйл ажиллагаа явуулахаар байгаль хамгаалах ажлын төлөвлөгөө батлуулсан хуулийн этгээдүүдийн судалгааг сумдаас авч нэгтгэх, тэдгээрийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, сумдын байгаль орчны мэргэжилтнүүдийг нэгдсэн арга зүйгээр хангах, ажлын хариуцлагыг дээшлүүлэх.

- Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэрсэн талбайг нөхөн сэргээх арга хэмжээ авах, нөхөн сэргээх зардлыг холбогдох хуулинд заасан хувь хэмжээгээр төлөвлүүлж, санхүүжүүлж байх.

Сумдын засаг дарга нарт:

- Хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдийн байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх ажилд шаардагдах зардлын тооцооллыг төлөвлөгөөнд үндэслэлтэй тусгуулж, түүний 50 хувьтай тэнцэх хэмжээний барьцааг орон нутгийн дансанд бүрэн төвлөрүүлэх.
- Хууль, журамд заасны дагуу нөхөн сэргээлтийн барьцааны тусгай дансыг Төрийн сан банкинд байршуулж, төвлөрсөн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, холбогдох байгууллагад үнэн зөвөөр тайлагнаж байх.
- Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, хайгуулын ажилд өртөгдсөн талбайн нөхөн сэргээлтийг актаар баталгаажуулан хүлээн авч баримтжуулж байх.
- Сумдын байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагчдыг холбогдох байгууллагатай ажлын уялдаа холбоотой ажиллуулж, хууль бусаар олборлолт явуулах эрсдэлтэй газруудыг тогтоож байнгын хяналт шалгалтыг хийлгэж байх, хууль бус үйлдлийг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлж байх.

Сумдын Төрийн сангийн төлөөлөгч нарт:

- Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 4.1-д заасны дагуу нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг үнэн зөв гаргаж сумын ИТХ болон БОАЖНХЯ-нд жилийн эцэст хүргүүлж байх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АХЛАХ АУДИТОР

С.БАТ-ЭРДЭНЭ

АУДИТОР

Б.ЭРДЭНЭЗУЛ